

ГАРЧИГ

Шүүхэд мэдүүлэх эрх	3
Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хэрхэн мэдүүлэх вэ?	4
Аль шүүхэд хандах вэ?.....	5
Хэргийн оролцогч та эдгээр эрхийг өөрөө бие даан хэрэгжүүлнэ	6
Хэргийн оролцогчдын бие даан хэрэгжүүлэх үүрэг	7
Хэргийн оролцогчид.....	8
Төлөөлөл	9
Хуулийн этгээдийг төлөөлөл	10
Шүүхийн оролцоотой хэрэгжүүлэх эрх, үүрэг	11
Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ	13
Шүүх хуралдаанд оролцогчийн эрх	15
Шүүх хуралдаанд оролцогчийн үүрэг	16
Шүүх хуралдаанд ирээгүйгээс үүсэх үр дагавар	17
Шүүх хуралдааны танхимд байж болохгүй хүмүүс.....	18
Шүүгчийн захирамж, Шүүхийн тогтоолд гомдол гаргах эрх	19
Шүүгчийн захирамж, Шүүхийн тогтоолд гомдол гаргах үндэслэлүүд	19
Шүүхийн шийдвэр	23
Шүүхийн шийдвэрт хэргийн оролцогчийн гомдол гаргах эрх	24
Шүүхийн шийдвэр, магадлалыг танилцуулах, гардуулах.....	27
Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл	28
Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа	29
Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсний (шийдвэрлүүлсний) үр дагавар	30

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

- Ж.ОЮУНТУНГАЛАГ** /Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч/
/Ажлын хэсгийн ахлагч/
- С.АМАРДЭЛГЭР** /Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч/
Б.ЦОЛМОНБААТАР /Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч/
Ж.САЙНХИШИГ /Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргаа, удирдлагын газрын дарга/
Г.ТӨРБОЛД /Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга/
- Т.ТҮМЭНЦЭЦЭГ** /Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Хууль зүйн асуудал хариуцсан референт/
/Нарийн бичгийн дарга/

БОЛОВСРУУЛСАН:

- С.АМАРДЭЛГЭР** /Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч/
"ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХ"
- Б.ЦОЛМОНБААТАР** /Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч/
"ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙН БИЕ ДААН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ, ҮҮРЭГ"
- Э.ЗОЛЗАЯА** /Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч/
"ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙН БИЕ ДААН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ, ҮҮРЭГ" ХЭСГИЙГ "ШҮҮХИЙН ОРОЛЦООТой ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ, ҮҮРЭГ"
- Д.НАРАНЦЭЦЭГ** /Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч/
"ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ"
- Н.ОЮУНТУЯА** /Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч/
"ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ, ШҮҮХИЙН ТОГТООЛД ГОМДОЛ ГАРГАХ ЭРХ"
- Д.ХУЛАН** /Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч/
"ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙН ГОМДОЛ ГАРГАХ ЭРХ"
- Н.САРАНГҮН** /Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч/
"ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА"

ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ЭРХ


Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /ИХШХШТХ/ 3 дугаар зүйл



ӨВ ЗАЛГАМЖЛАЛ



ГЭР БҮЛИЙН
МАРГААН



ХӨДӨЛМӨРИЙН
МАРГААН



ГЭРЭЭНИЙ МАРГААН



ЭРЭН СУРВАЛЖЛАХ



ГЭМ ХОР





ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ШҮҮХ



АЛБАН ТУШААЛТАН



ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА



ЗАХИРГААНЫ АКТ



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ШҮҮХ



ЦАГДАА, ПРОКУРОР
(ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ)

ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД ХЭРХЭН МЭДҮҮЛЭХ ВЭ?

ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйл

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАЖ
БУЙ ШҮҮХИЙН НЭРИЙГ
БИЧНЭ

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСАН
ӨДРИЙГ ТОДОРХОЙ
БИЧНЭ

НЭХЭМЖЛЭГЧ ӨӨРИЙН
БОЛОН ХАРИУЦАГЧИЙН
ОРШИН СУУГАА ХАЯГ
ОВОГ НЭР, ХОЛБОГДОХ
УТСЫГ ТОДОРХОЙ БИЧНЭ

ЯМАР ҮНДЭСЛЭЛЭЭР
ШААРДАЖ БАЙГААГАА
ТОДОРХОЙ ДУРДАНА

ХЭНЭЭС ЮУ ШААРДАЖ
БАЙГААГАА ТОДОРХОЙ
ДУРДАНА

НЭХЭМЖЛЭЛИЙН
ШААРДЛАГАА НОТОЛЖ
БУЙ БАРИМТ, УЛСЫН
ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ
ТӨЛСӨН БАРИМТ
ЗЭРГИЙГ ХАВСАРГАНА

НЭХЭМЖЛЭЛИЙГ
ХАРИУЦАГЧИЙН
ТООГООР ГАРГАНА

НЭХЭМЖЛЭЛ
ГАРГАСАН ХҮН
(КОМПАНИЙН ЗАХИРАЛ,
ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ) БАТАЛГААТ
ГАРЫН ҮСЭГ ЗУРНА

..... ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН
АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД

нэхэмжлэл гаргах нь

20.. оны .. сар .. өдөр

Нэхэмжлэгч:/овог/ /нэр/
Хаяг: аймаг/нийслэл сум/дүүрэг
..... баг/хороо гудамж, тоот
Утас:

Хариуцагч:/овог/ /нэр/
Хаяг: аймаг/нийслэл сум/дүүрэг
..... баг/хороо гудамж, тоот
Утас:

Нэхэмжлэлийн шаардлага:


Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл:

Хавсралт: /нийт хуудас/

Нэхэмжлэл гаргасан : Б.Д



Шүүхэд нэхэмжлэлийг
бичгээр гаргах бөгөөд
өөрөө болон шуудангаар
ирүүлж болно.

Улсын тэмдэгтийн
хураамжийг тооцоолохдоо
 **WWW.SHUUKH.MN**
сайтад хандана уу.



АЛ ШҮҮХЭД ХАНДАХ ВЭ?

ИХШХШТХ-ийн 14-19 дүгээр зүйл

ЕРДИЙН ТОХИОЛДОЛД




Хариуцагчийн оршин
суугаа газрын шүүх



ӨВЛӨГДӨХ ЭД
ХӨРӨНГИЙН ДИЙЛЭНХ
ХЭСЭГ БАЙГАА ГАЗАР



ҮЛ ХӨДЛӨХ ЭД
ХӨРӨНГӨТЭЙ
ХОЛБООТОЙ БОЛ
ТУХАЙН ЭД ХӨРӨНГӨ
БАЙГАА ГАЗАР




Шүүхийн онцгой
харьяалал



Нэхэмжлэгчийн
өөрийнх нь сонгосон
газрын шүүх

ХЭРГИЙН ОРОЛЦОГЧ ТА ЭДГЭЭР ЭРХИЙГ ӨӨРӨӨ БИЕ ДААН ХЭРЭГЖҮҮЛНЭ



ТАТГАЛЗАН ГАРГАХ

(ИХШХШТХ-ийн 91 дүгээр зүйл)




**ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦАА АВАХ**

(ИХШХШТХ-ийн ...)




ЭВЛЭРЭХ

(ИХШХШТХ-ийн 26.2, 26.3)



**НЭХЭМЖЛЭГЧ НЬ
ХАРИУЦАГЧИЙГ СОЛИХ**

(ИХШХШТХ-ийн 28 дугаар зүйл)



**ШҮҮХ ХУРАЛДААНД
ОРОЛЦОХ**

(ИХШХШТХ-ийн 25.1.2)



**НОТЛОХ БАРИМТ Г.М
ХЭРГИЙН МАТЕРИАЛТАЙ
ТАНИЛЦАХ**

(ИХШХШТХ-ийн 25.1.2)



**НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГАА
ӨӨРЧЛӨХ, НЭХЭМЖЛЭЛЭЭСЭЭ
ТАТГАЛЗАХ**

(ИХШХШТХ-ийн 26.2)



**ЭСРЭГ ТАЛЫН ТАЙЛБАР
НОТЛОХ БАРИМТТАЙ
ТАНИЛЦАХ**

(ИХШХШТХ-ийн 25.1.1)

ХЭРГИЙН ОРОЛЦОГЧДЫН БИЕ ДААН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ

(БИЕЛҮҮЛЭЭГҮЙГЭЭС ҮҮСЭХ ҮР ДАГАВРЫГ ТА ӨӨРӨӨ ХАРИУЦНА)



**ШИЙДВЭР, НЭХЭМЖЛЭЛИЙГ
ГАРДАН АВАХ**

(ИХШХШТХ-ийн 25.2.4, 25.2.6)



**ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОВ
ЛАВЛАХ**

(ИХШХШТХ-ийн 76.2)



**ШҮҮХЭД ҮНЭН ЗӨВ
ТАЙЛБАР ГАРГАХ**

(ИХШХШТХ-ийн 25.2.1)



**НОТЛОХ БАРИМТЫГ ӨӨРӨӨ
ГАРГАЖ ШҮҮХЭД ӨГӨХ**

(зөвхөн анхан шатны шүүхийн хэрэг
хянан шийдвэрлэх ажиллагааны явцад
хэрэгжүүлэх)

(ИХШХШТХ-ийн 25.2.2)



**ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ
САХИХ, ШҮҮХИЙН ТАВЬСАН
ШААРДЛАГЫГ БИЕЛҮҮЛЭХ**

(ИХШХШТХ-ийн 25.2.4, 25.2.5)



**ШҮҮХЭЭС ДУУДСАН ЦАГТ
ИРЭХ**

(ИХШХШТХ-ийн 25.2.3)



**ОРШИН СУУГАА ХАЯГАА
ӨӨРЧИЛСӨН БОЛ
МЭДЭГДЭХ**

(ИХШХШТХ-ийн 77.8)



**НЭХЭМЖЛЭЛИЙН ХУВИЙГ ГАРДАЖ
АВСНААС ХОЙШ 14 ХОНОГИЙН
ДОТОР ХАРИУ ТАЙЛБАР ГАРГАХ**

(зөвхөн анхан шатны шүүхэд)

(ИХШХШТХ-ийн 72.2)

ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИД

ИХШХШТХ-ийн 22-24 дугаар зүйл




НЭХЭМЖЛЭГЧ

ба түүний өмгөөлөгч, төлөөлөгч



ХАРИУЦАГЧ

ба түүний өмгөөлөгч, төлөөлөгч



ЗОХИГЧИЙН АДИЛ ЭРХ ЭДЭЛЖ, ҮҮРЭГ ХҮЛЭЭНЭ.

/Нэхэмжлэлийн шаардлагаа ихэсгэх, багасгах, зөвшөөрөх, эвлэрэхээс бусад/

ТӨЛӨӨЛӨЛ

ИХШХШТХ-ийн 32-36 дугаар зүйл

Та өөрөө оролцох боломжгүй бол бусдаар төлөөлүүлж болно



ИРГЭНИЙГ ТӨЛӨӨЛӨХ

ХУУЛЬД ЗААСНААР

САЙН ДУРААР БУЮУ ИТГЭМЖЛЭЛЭЭР

Та: Иргэний эрх зүйн чадамжгүй бол:

- 0-14 настай бол
- 14-18 настай бол

(ИХШХШТХ-ийн 32.3)

Таныг: Эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч төлөөлнө

(ИХШХШТХ-ийн 33.1)

Хэрэв иргэн сураггүй болсонд тооцогдсон бол

(ИХШХШТХ-ийн 32.3)

Түүнийг эд хөрөнгө нь эрхлэн хамгаалагчаар томилогдсон этгээд төлөөлнө.

(ИХШХШТХ-ийн 32.2)

Хэрэв иргэн нас барсан, нас барсанд тооцогдсон бол

(ИХШХШТХ-ийн 32.3)

- Түүний өв залгамжлагч
- Өвийг хүлээн аваагүй бол өвлөгдөх эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчаар томилогдсон этгээд түүнийг төлөөлөн оролцоно

(ИХШХШТХ-ийн 33.3)

Та хүсвэл


Өөр этгээдээр төлөөлүүлж болно

Энэ тохиолдолд итгэмжлэл олгоно.



ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛӨХ

Компани, ТББ, Нөхөрлөл,
Хоршоо гэх мэт



Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд:

- ТУЗ-ийн дарга
- Ерөнхий захирал
- Гүйцэтгэх захирал

Итгэмжлэл олгох замаар хуулийн этгээдийг өөр этгээдээр төлөөлүүлж болно.

Төлөөлүүлэгч итгэмжлэгдсэн төлөөлөлөгчөөсөө хэдийд ч татгалзаж болно. Энэ тухай шүүхэд заавал мэдэгдэнэ.

Шүүхэд итгэмжлэл өгнө.



**ДАРААХ ЭТГЭЭДИЙГ ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧӨӨР ОРОЛЦУУЛЖ БОЛОХГҮЙ**

- 18 насанд хүрээгүй (хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд)
- Өөрөө иргэнийхээ хувьд түүнчлэн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар буюу ажиллаж байгаа байгууллагаа төлөөлж байгаагаас бусад тохиолдолд шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч
- Иргэний эрх зүйн зарим буюу бүрэн бус чадамжтай, чадамжгүй иргэн
- Гэр бүлийн маргаантай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аль болох биечлэн оролцуулна.



ШҮҮХИЙН ОРОЛЦООТой ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ, ҮҮРЭГ

НОТЛОХ БАРИМТЫГ БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ

ИХШХШТХ-ийн 37-51 дүгээр зүйл

Нотлох баримт гэж маргааны талуудаас шүүхэд гаргасан тайлбарт дурдагдсан үйл явдал болсон эсэхийг нотлохоор гаргаж буй баримт сэлтийг хэлнэ.



ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

эсвэл

ШҮҮХИЙН ТОГТООЛ ГАРГАЖ НОТЛОХ БАРИМТЫГ БҮРДҮҮЛЭХ ЭСЭХИЙГ ШИЙДВЭРЛЭНЭ.

- Гэрчийн мэдүүлэг
- Бичиг баримт
- Эд мөрийн баримт
- Шинжээчийн дүгнэлт

Нотлох баримтыг хэргийн оролцогч өөрөө гаргаж өгөх үүрэгтэй.



Хэрэв :

- Өөр иргэн байгууллагад байгаа
- Маргааны эсрэг талд байгаа
- Өөрт нь байхгүй
- Өөрөө олж авах боломжгүй

Шүүхэд хүсэлт гаргана



ГЭРЧИЙН МЭДҮҮЛЭГ

ИХШХШТХ-ийн 43 дугаар зүйл

Маргааны талаар мэдэж буй хэн ч гэрч байж болно.

(Шүүхээс дуудаж асуусан тохиолдолд л гэрчийн мэдүүлэг баримт болно)

Гэхдээ дараах этгээд гэрч байж болохгүй



7 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД



СЭТГЭЦИЙН ӨВЧНИЙ УЛМААС ШҮҮХ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЧАДАМЖҮҮД ТООЦСОН ЭТГЭЭД



ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ, ӨМГӨӨЛӨГЧ, ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАГЧ

БИЧГИЙН НОТЛОХ БАРИМТ

ИХШХШТХ-ийн 44 дүгээр зүйл

Бичгийн нотлох баримт нь ЭХ ХУВЬ, эсхүл нотариатчаар гэрчлүүлсэн байна.



Төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд баримт гаргаж буй тохиолдолд өөрийн байгууллагын архивын "хуулбар үнэн" тэмдэг дарж баталгаажуулж болно. Энэ нь хэргийн оролцогчид хамаарахгүй юм.

Бичгийн нотлох баримтыг эх хувилбар, эсхүл нотариатчаар гэрчлүүлэх боломжгүй бол шүүхэд хүсэлт гаргах замаар үзлэг хийлгүүлж болно.



ЭД МӨРИЙН БАРИМТ

ИХШХШТХ-ийн 45 дугаар зүйл

Эд мөрийн баримт нь эд юмс байна.



ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

ИХШХШТХ-ийн 47 дугаар зүйл

Шинжлэх ухаан, техникийн тусгай мэдлэг шаардлагатай бол шинжээч томилуулна.



Шүүх хэргийн оролцогчийн хүсэлтийг үндэслэн шинжээч томилох шийдвэр гаргана

Шинжээч дүгнэлтээ бичгээр гаргана



ХАРИУЦАГЧ СОЛИХ

ИХШХШТХ-ийн 28 дугаар зүйл




Нэхэмжлэгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчаа солих эрхтэй



Энэ тохиолдолд тэрээр шүүхэд хүсэлт гаргана



Шүүх хүсэлтийг шийдвэрлэж, захирамж эсхүл тогтоол гаргана



Хариуцагч 1-ийг Хариуцагч 2-оор солив



ШҮҮХЭЭС ГАРАХ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Шүүхээс гарах шийдвэр баталгаатай биелэгдэх нөхцөл байдлыг урьдчилан бэлтгэхийн тул нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийг үндэслэн хуульд заасан арга хэмжээ авахыг хэлнэ.

Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний төрлүүд:



ЭД ХӨРӨНГӨ, МӨНГИЙГ БИТҮҮМЖИЛНЭ

ЭД ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ ЯМАР НЭГЭН АЖИЛЛАГАА ЯВУУЛАХЫГ



ДАНСНЫ ЗАРЛАГЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОГСООХ

НЭХЭМЖЛЭЛЭЭР ШААРДСАН МӨНГИЙГ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ДАНСАНД УРЬДЧИЛАН БАЙРШУУЛАХ



ТОДОРХОЙ АЖИЛЛАГАА ГҮЙЦЭТГҮҮЛЭХ, ЭСХҮЛ ГҮЙЦЭТГЭХГҮЙ БАЙХЫГ ДААЛГАХ

ОРЧУУЛАГЧ, ХЭЛМЭРЧ

ИХШХШТХ-ийн 49 дүгээр зүйл

Хэрвээ та Монгол хэл мэдэхгүй, эсхүл хэлгүй, дүлий зэрэг шалтгаантай бол



ХЭРГИЙН ОРЛОЦГОГЧИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ:

- Мэдүүлгийг орчуулж, хэлмэрчилнэ
- Хэргийн эсрэг талын оролцогчийн Шаардлага, Тайлбар, Мэдүүлэг, Татгалзалыг орчуулж, хэлмэрчилнэ
- Шүүх хуралдааны болон бусад ажиллагааг орчуулж, хэлмэрчилнэ
- Шүүхийн шийдвэрийг орчуулж, хэлмэрчилнэ
- Хэргийн материалтай танилцахад тусална

ОРЧУУЛАГЧИЙН ҮҮРЭГ:

- Шүүхийн дуудсанаар ирж, үнэн зөв орчуулах, хэлмэрчлэх үүрэгтэй
- Хэргийн материалтай танилцахад тусална




Зориуд худал орчуулсан хэлмэрчилсэн тохиолдолд орчуулагч, хэлмэрчид эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ

ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ

нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч

ИХШХШТХ-ийн 49 дүгээр зүйл




ШҮҮХ ХУРАЛДААНД БИЕЧЛЭН
ОРОЛЦОЖ, ТАЙЛБАР ГАРГАХ, НОТЛОХ
БАРИМТАА ЗААХ ЗАМААР МАРГАЛДАЖ
БАЙГАА ТАЛТАЙГАА МЭТГЭЛЦЭХ



НОТЛОХ БАРИМТ БҮРДҮҮЛЭХ,
ГАРГАЖ ӨГӨХ

Анхан шатны шүүх
Давж заалдах шатны шүүх
Хяналтын шатны шүүх



ШҮҮГЧ, ШҮҮХИЙН
ХУРАЛДААНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА, ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧ, ШИНЖЭЭЧ,
ХЭЛМЭРЧИЙГ ТАТГАЛЗАН
ГАРГАХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАХ



ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААТАЙ
ХОЛБООТОЙ ХҮСЭЛТ ГАРГАХ



ХЭРГИЙН МАТЕРИАЛ, НОТЛОХ
БАРИМТТАЙ ТАНИЛЦАХ,
НОТЛОХ БАРИМТ ШИНЖЛЭН
СУДЛАХАД ОРОЛЦОХ



БУСАД ОРОЛЦОГЧДОД
АСУУЛТ ТАВИХ



ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛД
3 ХОНОГИЙН ДОТОР ЗАСВАР
ОРУУЛАХ, САНАЛ ГАРГАХ

ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧИЙН ҮҮРЭГ

нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд,
тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч



ШҮҮХИЙГ ХҮНДЭТГЭХ, ШҮҮХ
ХУРАЛДААНЫ ТАНХИМД
ТОГТООСОН ЖУРМЫГ САХИХ

(ИХШХШТХ-ийн 25.2.5)



ШҮҮХ ХУРАЛДААНЫ
ТОВЫГ ШҮҮХЭЭС ЛАВЛАХ

(ИХШХШТХ-ийн 76.2)



БОДИТ ҮНЭНД НИЙЦСЭН
ТАЙЛБАР ӨГӨХ

(ИХШХШТХ-ийн 25.2.1)



ШҮҮХ ХУРАЛДААНЫ
ТОВЛОСОН ЦАГТ
ХҮРЭЛЦЭН ИРЭХ

(ИХШХШТХ-ийн 25.2.3)



МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХЭД
АЧ ХОЛБОГДОЛТОЙ
НОТЛОХ БАРИМТЫГ ЗААЖ
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

(ИХШХШТХ-ийн 110.1)



ОРШИН СУУХ ХАЯГАА
ӨӨРЧИЛСӨН БОЛ ШҮҮХЭД
МЭДЭГДЭХ

(ИХШХШТХ-ийн 77.8)



НЭХЭМЖЛЭГЧ НЭХЭМЖЛЭЛЭЭ,
ХАРИУЦАГЧ ТАТГАЛЗАЖ БАЙГАА
ҮНДЭСЛЭЛЭЭ НОТЛОХ БАРИМТЫГ
ШҮҮХ ХУРАЛДААНААС ӨМНӨ
ӨГСӨН БАЙХ

ШҮҮХ ХУРАЛДААНД ИРЭЭГҮЙГЭЭС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР



НЭХЭМЖЛЭГЧ

Нэхэмжлэлийг буцаах
(хэлэлцэхгүйгээр)

Хариуцагчийн хүсэлтээр
нэхэмжлэгчийн эзгүйд хэргийг
шийдвэрлэх

Улсын тэмдэгтийн хураамжийг
улсын орлого болгох

ИХШХШТХ-ийн 100.2 дүгээр зүйл



ХАРИУЦАГЧ

Нэхэмжлэгчийн хүсэлтээр,
хариуцагчийн эзгүйд
нэхэмжлэгчээс гаргасан
нэхэмжлэл, нотлох баримтыг
үндэслэн хэргийг шийдвэрлэх

Сөрөг нэхэмжлэлийг
хэлэлцэхгүй

ИХШХШТХ-ийн 100.3 дүгээр зүйл



ГУРАВДАГЧ ЭТГЭЭД

Бие даасан шаардлага гаргасан:

Бие даасан шаардлагыг
хэлэлцэхгүй буцаах

**Бие даасан шаардлага
гаргаагүй:**

Шүүх хуралдаанд зайлшгүй
оролцуулах шаардлагатай бол
албадан ирүүлж хуульд заасан
хариуцлага тооцох

ИХШХШТХ-ийн 100.2, 100.3,
77.9, 97.2 дүгээр зүйл



БУСАД ОРОЛЦОГЧ

Гэрч, шинжээч, орчуулагч,
хэлмэрч, иргэдийн төлөөлөгч
нарыг албадан ирүүлж, хуульд
заасан хариуцлага тооцох

ИХШХШТХ-ийн
77.9, 97.2 дүгээр зүйл

ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТАНХИМД БАЙЖ БОЛОХГҮЙ ХҮМҮҮС

ИХШХШТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.3



СОГТУУРСАН



МАНСУУРСАН



**НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮН
(ХЭРГИЙН ОРОЛЦОГЧ БИШ БОЛ)**




7 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД



**СЭТГЭЦИЙН ӨВЧНИЙ УЛМААС ШҮҮХ
ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЧАДАМЖГҮЙД
ТООЦСОН ЭТГЭЭД**

ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ, ШҮҮХИЙН ТОГТООЛД ХУУЛЬД ЗААСАН ТОХИОЛДОЛД ГОМДОЛ ГАРГАХ ЭРХТЭЙ

ИХШХШТХ-ийн 170.1 дүгээр зүйл



ГОМДОЛ ГАРГАХ ХУУЛЬД ЗААСАН ҮНДЭСЛЭЛҮҮД

ХЭРЭГ ШИЛЖҮҮЛСЭН:
(ИХШХШТХ-ийн 20.1)



НЭХЭМЖЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗСАН: (ИХШХШТХ-ийн 65.1)




- Шүүхэд харьяалагдахгүй
- Шүүхийн харьяалал зөрчсөн
- Урьдчилан шийдвэрлүүлэх журам зөрчсөн
- Нэхэмжлэлийг эрх зүйн чадамжгүй этгээд гаргасан
- Нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан
- Урьд нь маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэртэй
- Нэхэмжлэлтэй холбоотой хэргийг өөр шүүх шийдвэрлэж байгаа болон эрүүгийн журмаар шалгаж байгаа

НОТЛОХ БАРИМТТАЙ ХОЛБООТОЙ ШҮҮХ ХУРАЛДААНЫГ ХОЙШЛУУЛАХ: (ИХШХШТХ-ийн 38.9)



- Шинээр нотлох баримт шаардлагатай гэж үзэж баримтыг авахаар шүүх хуралдааныг хойшлуулсан
- Хэргээс нотлох баримтыг хассан
- Нотлох баримтыг шаардан авахаас татгалзсан




ШҮҮХЭЭС ГАРАХ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛСАН: (ИХШХШТХ-ийн 69.1)




- Хариуцагчийн эд хөрөнгө мөнгийг битүүмжилнэ
- Банкин дахь дансны гүйлгээг зогсоон, тодорхой үйл ажиллагаа явуулахыг болон явуулахгүй байхыг хариуцагчид даалгасан


ШҮҮГЧИЙГ ТАТГАЛЗАН ГАРГАХ ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭЖ АВАХГҮЙ ГЭЖ ШИЙДВЭРЛЭСЭН:
(ИХШХШТХ-ийн 92.4)



ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДЭГ ЗӨРЧСӨНТЭЙ ХОЛБООТОЙ МӨНГӨН ТОРГУУЛЬ ОНОГДУУЛСАН:
(ИХШХШТХ-ийн 97.1)



НЭХЭМЖЛЭЛИЙГ БУЦААСАН:
(ИХШХШТХ-ийн 100.2)



ХЭРГИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН:
(ИХШХШТХ-ийн 80.1)




ХЭРГИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН:
(ИХШХШТХ-ийн 117.1)



- *65.1.1 Шүүхэд харьяалагдахгүй
- *65.1.3 Урьдчилан шийдвэрлүүлэх журам зөрчсөн
- *65.1.4 Нэхэмжлэлийг эрх зүйн чадамжгүй этгээд гаргасан
- *65.1.5 Нэхэмжлэгийг төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан
- *65.1.6 Урьд нь маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэртэй
- *65.1.7 Нэхэмжлэлтэй холбоотой хэргийг өөр шүүх шийдвэрлэж байгаа
- *65.1.8 Нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа
- *65.1.10 Зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;

ШҮҮГЧ ӨӨРИЙН ЗАХИРАМЖ, ТОГТООЛЫГ ӨӨРЧИЛСӨН, ХУЧИНГҮЙ БОЛГОСОН:
(ИХШХШТХ-ийн 124.1)



ШҮҮХИЙН ШИЙДВЭР

ИХШШТХ-ийн 115 дугаар зүйл



НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАХ

Жишээ: Та 10 сая төгрөг нэхэмжилсэн бол хариуцагчаас 10 сая төгрөгийг гаргуулж, шийдвэрлэнэ.



НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГЫН ЗАРИМ ХЭСГИЙГ ХАНГАЖ, ҮЛДСЭНИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОХ

Жишээ: Та 10 сая төгрөг нэхэмжилсэн боловч хариуцагчаас 7 сая төгрөгийг гаргуулсан.




НЭХЭМЖЛЭЛИЙГ БҮХЭЛД НЬ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОХ

Жишээ: Та 10 сая төгрөг нэхэмжилсэн боловч хариуцагчаас төлбөр гаргуулаагүй шийдвэрлэсэн.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙН ГОМДОЛ ГАРГАХ ЭРХ


ИХШХШТХ-ийн 120.2, 167.1, 176.1, 25 дугаар зүйлийн 25.1.6



Хэрвээ Та давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлээгүй буюу анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргаагүй бол хяналтын журмаар гомдол гаргахгүй

ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАСНААС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР

ИХШХШТХ-ийн 122 дугаар зүйл




Шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан бол гомдлыг хянан шийдвэрлэж дуусах хүртлэх хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдахгүй.

Мөн анхан шатны шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулсан арга хэмжээ авсан бол энэ арга хэмжээ нь тухайн иргэний хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүхээр гомдлыг хянан шийдвэрлэж дуусах хүртлэх хугацаанд хэвээрээ байна.

ГОМДОЛ ГАРГАХ ХУГАЦААГАА ХЭТРҮҮЛСЭН БОЛ ХУГАЦАА СЭРГЭЭЛГЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ ТАЛААР

ИХШХШТХ-ийн 120 дугаар зүйлийн 120.3



Хэргийн оролцогч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нар

ХҮНДЭТГЭН ҮЗЭХ ШАЛТГААНААР



Шийдвэр, магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн хугацааг хэтрүүлсэн бол



ХУГАЦАА СУНГАХ ХҮСЭЛТ

Та хүсэлтээ Анхан шатны шүүхэд гаргана.



ХҮСЭЛТИЙГ ХАНГАХ ЭСЭХИЙГ ШҮҮГЧ ЗАХИРАМЖ ГАРГАН ШИЙДВЭРЛЭНЭ

ТАЙЛБАР:

Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт зохигч өвчтэй байх, МУ-ын нутаг дэвсгэрээс гадуур байх, эсхүл гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн гэх мэт хугацаа алдах, шүүхэд хүрэлцэн ирэх боломжгүй, эсхүл харгалзан үзэж болох нөхцөл бүрдсэн байхыг ойлгоно.

ҮҮНИЙГЭЭ БАРИМТААР НОТОЛСОН БАЙНА.

ГОМДОЛ ХААНА ГАРГАХ ВЭ?

ИХШХШТХ-ийн 163 дугаар зүйл



Давах, хяналтын гомдлыг анхан шатны шүүх хүлээн авч



ГОМДЛЫГ ХЭРГИЙН ХАМТ

Та давж заалдах гомдол болон хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлоо анхан шатны шүүхийн шийдвэрийг гаргасан шүүхдээ аваачиж өгнө.

Та шууд Аймаг, нийслэлийн шүүхэд болон Улсын шүүхэд аваачиж өгөх юм бол гомдлыг тань хүлээж авахгүй. Та гомдол гаргах хугацаа алдахыг анхаарна уу.



Аймаг, нийслэлийн шүүх Улсын Дээд шүүхэд хүргүүлнэ

ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ

ИХШХШТХ-ийн 162.1

ГОМДОЛ ГАРГАЖ БУЙ
ШҮҮХИЙН НЭРИЙГ
БИЧНЭ

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСАН
ӨДРИЙГ ТОДОРХОЙ
БИЧНЭ

ГОМДОЛ ГАРГАГЧИЙН
ОРШИН СУУГАА ХАЯГ
ОВОГ НЭР, ХОЛБОГДОХ
УТСЫГ ТОДОРХОЙ БИЧНЭ

ШИЙДВЭРИЙН
АЛЬ ХЭСГИЙГ
ЗӨВШӨӨРӨХГҮЙ
БАЙГААГАА ТОДОРХОЙ
ДУРДАХ

АЛЬ ШҮҮХИЙН ЯМАР
ШИЙДВЭРТ ГОМДОЛ
ГАРГАЖ БАЙГААГАА
БИЧНЭ

ШҮҮХИЙН
ШИЙДВЭРИЙГ
ЗӨВШӨӨРӨХГҮЙ
БАЙГАА ХЭМЖЭЭГЭЭР
УЛСЫН ТЭМДЭГТИЙН
ХУРААМЖИЙГ ТООЦОН
ТӨЛНӨ.

ГОМДОЛ ГАРГАГЧИЙН
ГАРЫН ҮСЭГ

..... ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ
ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭД

Гомдол гаргах нь

20.. оны .. сар .. өдөр


Гомдол гаргагч: /овог/ /нэр/
Хаяг: аймаг/ нийслэл сум/ дүүрэг
..... баг/ хороо гудамж, тоот
Утас:

Хүлээн зөвшөөрөхгүй байгаа шүүхийн шийдвэрийн
огноо, дугаар


Гомдлын үндэслэл:

Хавсралт: /нийт хуудас/

Гомдол гаргасан : Б.Д




Давж заалдах гомдлоо
бичгээр гаргах бөгөөд өөрөө
болон шуудангаар анхан
шатны шүүхэд ирүүлж болно.

Улсын тэмдэгтийн
хураамжийг тооцоолохдоо
 WWW.SHUUKH.MN
сайтад хандана уу.


ШҮҮХИЙН ШИЙДВЭР, МАГАДЛАЛЫГ ТАНИЛЦУУЛАХ, ГАРДУУЛАХ

ИХШХШТХ-ийн 119 дүгээр зүйлийн 119.4-119.8, 167.4-167.6



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ ҮНДЭСЛЭЛ

ИХШХШТХ-ийн 183 дүгээр зүйл




ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ИХШХШТХ-ийн 74.1, 74.2, 106.5 дүгээр зүйл

НЭХЭМЖЛЭГЧ НЭХЭМЖЛЭЛЭЭСЭЭ ТАТГАЛДСАН

Шүүхэд гаргасан гомдол хүсэлтээ өөрөө сайн дураараа авахыг нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах гэнэ.

Жишээ нь: А нь Б-гээс 1 сая төгрөг нэхэмжилсэн. А-г шүүхэд нэхэмжлэл гаргах үед Б төлбөрийг төлсөн бол А шүүхэд гаргасан нэхэмжлэлээсээ татгалзана.



ХАРИУЦАГЧ НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГЫГ БИЕЛҮҮЛСЭН

Шүүхэд хандаж нэхэмжлэлд бичсэн зүйлийг хариуцагч биелүүлснийг ойлгоно.

Жишээ нь: А нь Б-гээс 1 сая төгрөг нэхэмжилсэн. Энэхүү нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авснаас хойш 13 хоногт багтаан 1 сая төгрөгийг төлсөн.

ХАРИУЦАГЧ НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГЫГ ЗӨВШӨӨРСӨН

Нэхэмжилсэн зүйлийг эсэргүүцэхгүй зөвшөөрөхийг хэлнэ.


Жишээ нь: А нь Б-гээс 1 сая төгрөг нэхэмжилсэн бөгөөд Б түүнийг төлөхийг хүлээн зөвшөөрч тайлбараа гаргасан.



НЭХЭМЖЛЭГЧ ХАРИУЦАГЧ НАР ЭВЛЭРСЭН

Нэхэмжлэлийн шаардлагын талаар нэхэмжлэгч хариуцагч нар харилцан тохиролцохыг хэлнэ.

Жишээ нь: А нь Б-гээс 1 сая төгрөг нэхэмжилсэн. Б уг мөнгийг хүлээн зөвшөөрсөн боловч санхүүгийн боломжгүй байдлаа А-д хэлсэн. Б нь 500 мянган төгрөгт тооцон гар утсаа өгч үлдэх мөнгийг 3 сарын хугацаанд төлөхөөр тохирсон.



ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ



ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСНИЙ (ШИЙДВЭРЛҮҮЛСНИЙ) ҮР ДАГАВАР

ИХШХШТХ-ийн 74.1, 74.2, 106.5 дүгээр зүйл




Уг асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхгүй
(ИХШХШТХ-ийн 74.4)



Нэхэмжлэгч, хариуцагч нар дээд шатны шүүхүүдэд гомдол гаргах эрхгүй
(ИХШХШТХ-ийн 74.4)




Хариуцагч захирамжийг биелүүлэхгүй бол шүүхийн шийдвэрийн адил албадан гүйцэтгэнэ
(ИХШХШТХ-ийн 74.4, 75.6)



Бүгдийг нь Шүүх баталгаажуулна
(ИХШХШТХ-ийн 74.4)

ИРГЭНИЙ ХЭРЭГ ҮҮСГЭСНИЙ ДАРАА



ТЭМДЭГЛЭЛ



A series of 20 horizontal lines, evenly spaced, providing a template for writing.

ТЭМДЭГЛЭЛ